ХАНГАРЬД СПОРТ КЛУБИЙН НЭРЭМЖИТ УСАНД СЭЛЭЛТИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН-2024

Орхон аймаг, Эрдэнэт хот
2024 оны 9-р сарын
21,22

БАТЛАВ:

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ-ЫН
СПОРТ ЦОГЦОЛБОРЫН ДАРГА

Ш. ДАВААХҮҮ
2024он……сар…..өдөр

Агуулга:

1. Тэмцээний мэдээлэл. 3
2. Ерөнхий мэдээлэл. 3
3. Насны ангилал 3
4. Тэмцээний бүртгэл 3
5. Буцаалт. 4
6. Медаль, диплом, цом 4
7. Тэмцээний байршил 5
8. Бие халаалтын заавар 5
9. Тэмцээний төрөл. 6
10. Тэмцээний хөтөлбөр 7
11. Тэмцээнд оролцогчдын ёс зүйн хэм хэмжээ 9

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Спорт цогцолбор
“Хангарьд” спорт клуб,
“Хангарьд” спорт клубийн эцэг эхийн зөвлөл

1. ТЭМЦЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Тэмцээн:
Хангарьд спорт клубийн нэрэмжит усанд сэлэлтийн аварга шалгаруулах тэмцээн нь 2024.09. 20-22-ны өдрүүдэд зохион байгуулагдана.

Байршил: Орхон аймаг, Эрдэнэт хот, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн Спорт цогцолборын усан сан

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. Хангарьд спорт клубийн нэрэмжит усанд сэлэлтийн аварга шалгаруулах тэмцээн нь World Aquatics- ын Тэмцээний дүрэм (Competition regulations)-ийг мөрдөж явагдана
2.2. Тэмцээнийг ганцаарчилсан болон буухиа төрлөөр зохион байгуулна, буухианд 1 клубээс 1 баг оролцоно.

3. НАСНЫ АНГИЛАЛ

3.1 Насны бүлэг: 8-9 нас, 10-11нас, 12-13нас, 14-15нас, 16-17нас
3.2 Насны бүлгийг 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тооцно
3.3 Тамирчид ганцаарчилсан болон буухиа уралдаанд зөвхөн өөрийн насны бүлэгт өрсөлдөнө.

Насны бүлэг	Төрсөн он
8-9	2016-2015
10-11	2014-2013
12-13	2012-2011
14-15	2010-2009
16-17	2008-2007

4. ТЭМЦЭЭНИЙ БҮРТГЭЛ

4.1. Тэмцээний бүртгэл 2024 оны 09 сарын 01-ний 10:00 цагт нээгдэх бөгөөд 2024 оны 09 сарын 14-ны өдрийн 23:59 цагт хаагдана.
4.2. Тамирчин бүр оролцооны мөнгө 50.000 төгрөгийг Хаан банкны 5217208656 дансанд шилжүүлж бүртгэл баталгаажна.
4.3. Мэдүүлгээ тогтоосон хугацаанд гаргасан бүх тамирчид тэмцээнд оролцох эрхтэй.
4.4. Багийн мэдүүлгийг EXEL файлаар Boldbaatar0828@gmail.com хаягаар илгээнэ.
4.5. Техникийн зөвлөгөөнд багийн дасгалжуулагчид оролцоно.

5. БУЦААЛТ

5.1. Багийн дасгалжуулагч гарааанд гараагүй тамирчны маягтыг бөглөж, эрүүл мэндийн магадлагааны хамт гараа эхлэхээс 30 минутаас багагүй хугацааны өмнө Ерөнхий шүүгчид хүргүүлсэн байна.

5.2. Эрүүл мэндийн шалтгаанаар гарааанд гараагүй тамирчин тухайн өдрийн бусад гарааанд оролцох эрхгүй.

5.3. Тэмцээнийг зохион байгуулагчдын буруутай үйлдлээс болж баг/тамирчин ямар нэг алдаа гаргаж шийтгэл хүлээсэн нь тогтоогдвол баг/тамирчны шийтгэлийг нэн даруй хүчингүй болгож амжилтыг сэргээж, цаашид тэмцээнээ үргэлжлүүлэх боломжоор хангана.

6. МЕДАЛЬ, ДИПЛОМ, ЦОМ

Хангарьд спорт клубийн АШТ-ний шагналыг дараах байдлаар олгоно:

6.1. Ганцаарчилсан уралдааны эхний гурван байранд орсон тамирчдад Алт, Мөнгө, Хүрэл медаль, диплом олгоно.

6.2. Буухиа уралдааны эхний гурван байранд орсон баг тамирчдад Алт, Мөнгө, Хүрэл медаль, диплом олгоно.

7. ТЭМЦЭЭНИЙ БАЙРШИЛ

7.1. Орхон аймаг, Эрдэнэт хот, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн Спорт цогцолбор.

7.2. Холбогдох утас: +976-99351689, +976-80181316

8. БИЕ ХАЛААЛТЫН ЗААВАР

8.1. Тэмцээн эхлэхээс 90 минутын өмнө тамирчдын бие халаалт эхэлнэ.
8.2. Бие халаалтын журмын биелэлтийг Ерөнхий шүүгч хянаж ажиллана.
8.3. Баг тамирчид зөвхөн зохион байгуулагчдын гаргасан хуваарийн дагуу халаалтаа хийх бөгөөд багийн ахлагчид хяналт тавих үүрэгтэй.
8.4. Тамирчид усан сангийн ирмэг дээр суусан байрлалаас хөлөөрөө ус руу орно. Ус руу үсэрч орохыг хатуу хориглоно.
8.5. Бие халаалтын үндсэн замуудыг доорх зурагт үзүүлсний дагуу тойрог хэлбэрээр хоёр чиглэлд сэлэхэд ашиглах бөгөөд тус замд шумбалт хийхийг хориглоно.
8.6. Хурдтай сэлэлтийн болон араар даллах сэлэлтийн замыг зөвхөн нэг чиглэлд ашиглах бөгөөд зөвхөн энэ замд шумбалт хийхийг зөвшөөрнө.
8.7. Бие халалтын үед сэлүүр ашиглахыг хориглоно.
8.8. Дасгалжуулагчид бие халаалтын журам болон аюулгүй байдлын зааварчилгааг тамирчдадаа өгөх үүрэгтэй бөгөөд бие халаалтын үеэр байнга хамт байж аюулгүй байдалд нь хяналт тавина. Бусад багуудын халаалтын цаг болоход тамирчдаа усан сангаас даруй гаргах үүрэгтэй.
8.9. Автомат цагийн мэдрэгч хавтан суурилуулсан талаар усан сангаас гарах тамирчид зөвхөн хажуу талын хананы дагуу усан сангаас гарна.
8.10. Бие халаалтын журам зөрчсөн тамирчныг Ерөнхий шүүгч болон тэмцээний зохион байгуулагчид усан сангаас нэн даруй гаргана
8.11. Тэмцээн эхлэхээс 15 минутын өмнө усан бассейныг чөлөөл



9. ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ

№	Зай төрөл	8-9нас	10-11нас	12-13нас	14-15нас	16-17нас
1	50м өвөр	+	+	+	+	+
2	100м өвөр	+	+	+	+	+
3	50м ар	+	+	+	+	+
4	100м ар	+	+	+	+	+
5	50м мэлхий	+	+	+	+	+
6	100м мэлхий	+	+	+	+	+
7	50м далайн гахай	+	+	+	+	+
8	100м далайн гахай	+	+	+	+	+
9	100м холимог	+	+			
10	200м холимог			+	+	+
11	400м өвөр			+	+	+
12	БуухиаMIX 4*50 холимог	+	+	+	+	+

10. ТЭМЦЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хугацаа	Үйл ажиллагаа
09 сарын 20	
10:00-18:00	Багуудын бие халаалт
18:00	Техникийн зөвлөгөөн
19:00	Шүүгчдийн зөвөлгөөн
09 сарын 21	
08:30-09:45	Бие халаалт
10:00-10:20	Нээлтийн үйл ажиллагаа
10:30	Буухиа 4*50м холимог MIX /12-13, 14-15, 16-17/ 100м өврөөр даллах сэлэлт эрэгтэй, эмэгтэй /8-9, 10-11/ 100м өврөөр даллах сэлэлт эрэгтэй, эмэгтэй /12-13, 14-15, 16-17/ 50м далайн гахай сэлэлт эрэгтэй, эмэгтэй /8-9, 10-11/ 50м далайн гахай сэлэлт эрэгтэй, эмэгтэй /12-13, 14-15, 16-17/ 100м мэлхий сэлэлт эрэгтэй, эмэгтэй / 8-9, 10-11/ 100м мэлхий сэлэлт эрэгтэй, эмэгтэй /12-13, 14-15, 16-17/ 50м араар даллах сэлэлт эрэгтэй, эмэгтэй / 8-9, 10-11/ 50м араар даллах сэлэлт эрэгтэй, эмэгтэй /12-13, 14-15, 16-17/ 100м холимог сэлэлт эрэгтэй, эмэгтэй /8-9, 10-11/ 200м холимог сэлэлт эрэгтэй, эмэгтэй /12-13, 14-15, 16-17/
	Шагнал гардуулах үйл ажиллагаа
09 сарын 22	
08:30-09:45	Бие халаалт
10:00	400м өврөөр даллах сэлэлт эрэгтэй, эмэгтэй /12-13, 14-15, 16-17/ 100м далайн гахай сэлэлт эрэгтэй, эмэгтэй / 8-9, 10-11/ 100м далайн гахай сэлэлт эрэгтэй, эмэгтэй /12-13, 14-15, 16-17/ 50м мэлхий сэлэлт эрэгтэй, эмэгтэй / 8-9, 10-11/ 50м мэлхий сэлэлт эрэгтэй, эмэгтэй /12-13, 14-15, 16-17/ 100м араар даллах сэлэлт эрэгтэй, эмэгтэй / 8-9, 10-11/ 100м араар даллах сэлэлт эрэгтэй, эмэгтэй /12-13, 14-15, 16-17/ 50м өврөөр даллах сэлэлт эрэгтэй, эмэгтэй / 8-9, 10-11/ 50м өврөөр даллах сэлэлт эрэгтэй, эмэгтэй /12-13, 14-15, 16-17/ Буухиа 4*50м холимог MIX / 8-9, 10-11/
	Шагнал гардуулах үйл ажиллагаа
	Хаалтын үйл ажиллагаа

11. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

12.1 Тэмцээнд оролцогч тамирчид, дасгалжуулагчид, баг хамт олон, эцэг эхчүүд болон хөгжөөн дэмжигчид доорхи ёс зүйн хэм хэмжээг баримтлана. Үүнд:

12.2 Үнэнч шударгаар өрсөлдөж, ёс зүйн аливаа зөрчил гаргахаас зайлсхийх

12.3 Тэмцээнийг зохион байгуулагчид болон бусад тамирчид, хэвлэл мэдээлэл болон үзэгчдийн эсрэг заналхийлсэн, хүчирхийлсэн, үл хүндэтгэсэн зан авир гаргахгүй байх.

12.4 Бусдыг үндэс угсаа, арьсны өнгө, нас хүйс, шашин шүтлэг, хэл соёл, хувийн үзэл бодол, өмч хөрөнгө, хөгжлийн бэрхшээл болон бусад бүх үндэслэлээр ялгаварлан гадуурхахаас зайлсхийх.

12.5 Тэмцээний үйл ажиллагаа, зохион байгуулалтад саад учруулах, хөндлөнгөөс оролцох, тогтоосон дэгийг зөрчихгүй байх. Энэ заалт нь усан сангийн бүх хэсэг болон тухайн арга хэмжээний гадна талбайд болсон зөрчилд ч хамаарна.

12.6 Тэмцээний бүхий л үйл ажиллагаа буюу нээлт , хаалт, шагнал гардуулах ёслолд идэвхтэй оролцох.

12.7 Сэргээшийн эсрэг хөтөлбөрийг дэмжиж, дэлхийн сэргээшийн эсрэг дүрмээр хориглосон ямар нэг бэлдмэл, зан үйлийг ашиглахгүй байх

11.9 Согтууруулах ундаа болон утаат болон цахилгаан тамхи (vape) хэрэглэхийг хатуу хориглоно. Энэ заалт нь усан сангийн бүх хэсэг болон тухайн арга хэмжээний гадна талбайд болсон зөрчилд ч хамаарна.

11.10 Тамирчдын насыг санаатайгаар буруу мэдээлэх, холбогдох баримтыг засварлах, хуурамчаар үйлдэхгүй байх.

11.11 Эдгээр ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл/эс үйлдлийг тэмцээнийг зохион байгуулах хороонд мэдэгдэж хамтран ажиллах

ХЯНАСАН
АХЛАХ АРГА ЗҮЙЧ Э. ЭРДЭНЭБАЯР

БОЛОВСРУУЛСАН

АРГА ЗҮЙЧ С. АЛТАНТУЯА